






Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын  
11-ний өдрийн 255 дугаар тогтоолоор баталсан  
“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт маягт 2

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2024 оны II улирал (2024 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр)
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: Ард Кредит ББСБ ХК, УБД: 9010002003, ҮЦК: ADB, Утасны дугаар: +976 77003322
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк бус санхүүгийн байгууллага
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	364,000,000 (Гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг
Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: ТУЗ Нарийн бичгийн дарга Г.ЕСҮ-ҮЖИН Хянаж, баталсан: Гүйцэтгэх захирал Г.СҮХБААТАР
<p>1. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</p>	
Санхүүгийн байдлын үзүүлэлт	2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт актив 83.7 тэрбум төгрөг, үүнээс цэвэр зээлийн багц 54.5 тэрбум байгаа бол нийт эздийн өмч 28.7 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 55.0 тэрбум төгрөг байна.
Орлогын тайлан	2024 оны 2-р улиралд өссөн дүнгээр хүүгийн орлого 8.5 тэрбум төгрөг, хүүгийн зардал 3.7 тэрбум төгрөг, хүүгийн бус орлого 1.8 тэрбум, бусад үйл ажиллагааны орлого 774 сая төгрөгт хүрч өссөн бол хүүгийн бус зардал 4.3 тэрбум, эрсдэлийн сангийн зардал 1 тэрбум, бусад үйл ажиллагааны ашиг зардал 201 сая, орлогын албан татварын зардал 268 сая төгрөг байна. Улмаар эхний хагас жилд 1.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллав.
Өмчийн өөрчлөлтийн тайлан	ҮРӨ гаргасантай холбоотойгоор хувь нийлүүлсэн хөрөнгө 840 сая төгрөгөөр, нэмж төлөгдсөн капитал 7.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэв. Харин ногдол ашиг тараах шийдвэрийн дагуу харимтлагдсан ашиг 1 тэрбум төгрөгөөр буурсан бол дахин үнэлгээний үнэ цэнийн бууралт 851 сая төгрөгөөр нэмэгдэв. Улмаар эздийн өмч тайланг хугацааны эхэнд 20.9 тэрбум төгрөг байснаас 28.7 тэрбум төгрөг болж нэмэгдэв.

	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 7.2 тэрбум төгрөг, эцсийн үлдэгдэл 6.9 тэрбум төгрөг байна. Тайлант хугацаанд 61.2 тэрбумын зээл олгож, 55.3 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн эргэн төлөлт хийгджээ.						
2.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>							
		Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2024 оны 7 сарын 05-ны өдрийн 24/02 тоот зөвлөмжөөр хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-өөр баталгаажуулахаар хүргүүлж, 2024 оны 7 сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулсан.						
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжлэгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>							
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	<table border="1" data-bbox="826 736 1422 836"> <tr> <td>Цэвэр ашгийн хувь</td> <td>15.4%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж</td> <td>13.0%</td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгийн өгөөж</td> <td>4.2%</td> </tr> </table>	Цэвэр ашгийн хувь	15.4%	Өөрийн хөрөнгийн өгөөж	13.0%	Нийт хөрөнгийн өгөөж	4.2%
Цэвэр ашгийн хувь	15.4%							
Өөрийн хөрөнгийн өгөөж	13.0%							
Нийт хөрөнгийн өгөөж	4.2%							
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгий нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 13.7% Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа (D/E) 1.5 Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 35.5%						
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	<p>1. Ард Апп идэвхтэй ашигладаг үнэнч харилцагч нартаа зориулан хэрэглээний онлайн зээлийн нөхцөл шинэчлэл оруулж, зээлийн хүү, шимтгэлийг бууруулав.</p>  <p>2. Автомашины зээлийн хүсэлтийг Ард Аппаар шийдвэрлэдэг болов</p>  <p>3. Монголбанкнаас Цахим мөнгөний зөвшөөрлийг хугацаагүй олгов.</p>  <p>4. Мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 магадлах аудитын баталгаажуулалтын гэрчилгээ авав.</p>  <p>5. Байгаль Орчин Нийгэм Засаглал /БОНЗ/-ын хороог байгуулав.</p> 						

3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Тухайн тайланд хугацаанд тэнцлийн гадуур зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээлийн үлдэгдэл 738.5 сая төгрөг, хүү хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн үлдэгдэл 411.3 сая төгрөг байна.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	<p>Их хэмжээний хэлцэл: Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.</p> <p>Сонирхлын зөрчилтэй хэлцэл. 2024 оны 1-р улиралд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-нд 500,000,000.00 төгрөгийг 2 сарын хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.01.26</li> <li>2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-нд 100,000,000.00 төгрөгийг 7 хоногийн хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.02.09</li> <li>3. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-нд 850,000,000.00 төгрөгийг 7 хоногийн хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.02.14</li> <li>4. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-нд 500,000,000.00 төгрөгийг 1 сарын хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.03.05</li> <li>5. Скоп Аллианс ХХК-тай 1,203,221,000.00 төгрөгийн авлагын гэрээ байгуулах эрхийг олгов. Огноо: 2024.03.05</li> </ol> <p>2024 оны 2-р улиралд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ард Пропертиз ХХК-тай үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг байгуулав. Огноо: 2024.03.27</li> <li>2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-нд 300,000,000.00 төгрөгийг 2 сарын хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.04.03</li> <li>3. Ард Лизинг ХХК-д 1,000,000,000.00 төгрөгийн шугамын зээлийн эрхийг 1 жилийн хугацаатайгаар нээв. Огноо: 2024.06.06</li> </ol>
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	<p>Тус тайлангийн хугацаанд “Ард Кредит ББСБ” ХК нь нийтэд санал болгон нэмж гаргасан нэг бүр нь 106 төгрөгийн үнэтэй, нийт 8,904,000,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий 84,000,000.00 ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийг дуустал хүлээн авч, арилжааг амжилттай зохион байгууллаа.</p> <p>Анхдагч зах зээлийн арилжаагаар 9,105,862,160.00 төгрөгийн үнийн дүн бүхий 1,583 захиалга ирүүлсэн бөгөөд үнэт цаасны танилцуулга болон андеррайтерийн компаниас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга болон олон нийтээс ирүүлсэн 500,000.00 /таван зуун мянга/ төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хувьцааны захиалгыг 100 хувь биелүүлж, үлдсэн дүнг 94.6 хувиар хувь тэнцүүлэн нийлүүлэхээр хуваарилалтыг хийсэн болно.</p> <p>Санхүүгийн Зохицуулах Хорооны 2023 оны 9 дүгээр сарын 01-нн өдрийн 428 тоот тогтоолоор үнэт цаасыг нийтэд санал болгох зөвшөөрлийг олгож, 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн төвөөр дамжин нийт 8,904,000,000.00 төгрөг олон нийтээс татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс СТОУС дагуу үнэт цаас гаргахтай шууд хамаарал</p>

бүхий зардал 770,146,893.68 төгрөгийг хасагдуулж цэвэр 8,133,853,106.32 төгрөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн бүртгэсэн.

Ард Кредит ББСБ ХК нь 2024 оны 3 сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 сарын 30 хүртэлх хугацаанд FPO татан төвлөрүүлсэн хөрөнгийн 73.4% буюу (30.0 хувь буюу нийт 2.4 тэрбум төгрөгийг хөрөнгө барьцаалсан зээлд, 20.0% буюу 1.6 тэрбум төгрөгийг хэрэглээний онлайн зээлд, 23.4% буюу 1.9 тэрбум төгрөгийг бичил, жижиг дунд бизнесийн зээлд) нийт 6.0 тэрбум төгрөгийг төлөвлөгөөний дагуу зарцуулаад байна. Үлдэгдэл 2.2 тэрбум төгрөгөөс тодорхой хувийг шугамын зээлийн эргэн төлөлтөд хийж үлдэгдэл мөнгийг харилцах дансанд хадгалж байна.

Ангилал	Зарцуулалтын төлөвлөгөө		Зарцуулалтын гүйцэтгэл	
	Үнийн дүн /₮ сая/	Хувь	Үнийн дүн /₮ сая/	Хувь
Хөрөнгө барьцаалсан зээл	2,440.2	30.0%	2,440.2	30.0%
Хэрэглээний зээл	1,626.8	20.0%	1,626.8	20.0%
Бичил жижиг дунд бизнесийн зээл	4,066.9	50.0%	1,903.0	23.4%
Нийт	8,133.9	100.0%	5,969.9	73.4%

6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

- Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн өөрийн хүсэлтээр албан тушаалаасаа чөлөөлөгдөн, Гүйцэтгэх захирлаар Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Бизнес хөгжил эрхэлсэн захирлаар ажиллаж байсан Г.Сүхбаатар томилогдов.
- Ард Кредит ББСБ ХК-ийн зүгээс Хөрөнгө оруулагч, Хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг бүрэн, үнэн зөв, цаг алдалгүй хүргэхээр ажиллаж тайлант хугацаанд Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр, Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг тус тус батлав.
- Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх, компанийн засаглалын кодекст нийцүүлэн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмуудыг шинэчлэн батлав.

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

2024 оны эхний хагас жилийн байдлаар дараах тайлан мэдээллүүдийг холбогдох хууль, тогтоомжид заасан хугацаанд илгээж, олон нийтэд мэдээлсэн байна.

- 2023 оны жилийн санхүү болон үйл ажиллагааны тайлан;
- 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, дүгнэлт;
- 2024 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны тайлан;
- Компанийн Засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга;
- 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал болон шийдвэр;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол;
- Үнэт цаас гаргагчаас тухай бүр мэдээлэх мэдээлэл;

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Сүхбаатар

Албан тушаал: “Ард Кредит ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Есү-Үжин

Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Гарын үсэг: .....

